



**УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖААНЫ
ТОЙМ - 2025 ОНЫ III УЛИРЛЫН БАЙДЛААР**


МХБ-ээр арилжигдсан уул уурхайн бүтээгдэхүүний 2025 оны 3 дугаар улирлын арилжааны тойм

2025 оны III улирлын байдлаар нийт 780 удаагийн уул уурхайн бүтээгдэхүүний цахим дуудлага арилжаа зохион байгуулагдсан байна. Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК, “Энержи Ресурс” ХХК, “Хангад Эксплорэйшн” ХХК, “Андын Илч” ХХК, “Мөнх Тэнүүн Оргил” ХХК нь 12.54 сая тонн нүүрсийг 3.04 их наяд төгрөгөөр, “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ, “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК нь нийт 4.15 сая тонн төмрийн хүдэр, баяжмалыг 902.25 тэрбум төгрөгөөр, “Очир Мандал Хайрхан” ХХК, “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ нь нийт 41,470 тонн хайлуур жоншны хүдэр, баяжмалыг 43.28 тэрбум төгрөгөөр, “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ 35,000 тонн зэсийн баяжмалыг 248.58 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалсан бөгөөд нийт 16.77 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 4.24 их наяд төгрөгөөр арилжаалсан байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа

2025 оны III улирлын байдлаар нийт 393 удаагийн арилжаа амжилттай зохион байгуулагдаж нийт 16,765,770 тонн уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалснаас нүүрсний арилжаагаар 12,537,600 тонн нүүрс, төмрийн арилжаагаар 4,151,700 тонн төмрийн хүдэр болон баяжмал, жоншны арилжаагаар 41,470 тонн хайлуур жоншны хүдэр болон баяжмал, зэсийн арилжаагаар 35,000 тонн зэсийн баяжмал тус тус арилжигдсан байна. Нийт арилжааны 74.78 хувийг нүүрсний арилжаа, 24.76 хувийг төмрийн хүдэр болон баяжмалын арилжаа, 0.25 хувийг хайлуур жоншны хүдэр болон баяжмалын арилжаа, 0.21 хувийг зэсийн арилжаа тус тус эзэлж байна.

График 1. Нийт уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны тоо хэмжээнд эзлэх хувь.




1. Нүүрсний арилжаа

Тайлант хугацаанд нийт 213 удаагийн нүүрсний дуудлага арилжаа амжилттай зохион байгуулагдаж 12,537.6 мянган тонн нүүрсийг 3.04 их наяд төгрөгөөр арилжсан байна. Дуудлага худалдаагаар арилжсан нүүрсний үнийн өсөлтийн дундаж 8.05 хувь байна. Худалдагч компаниуд дуудлага арилжаагаар арилжигдсан нүүрсний үнийн өсөлтөөс нийт 139.9 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна.

Хүснэгт 1. Нийт арилжигдсан нүүрсний хэмжээ, үнийн дүн.

№	Бүтээгдэхүүний ангилал	Хэмжээ тн	Үнийн дүн ₮
1	Дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс	3,692,800	1,122,768,126,784
2	Эрчим хүчний нүүрс /Битумт, үл барьцалдах нүүрс/	3,084,800	412,302,236,992
3	1/3 коксжих нүүрс	2,969,600	744,660,435,034
4	Баяжуулсан коксжих нүүрс	953,600	389,665,184,122
5	Баяжуулсан дунд зэрэг үнстэй, хагас хатуу коксжих нүүрс	614,400	106,170,887,040
6	Баяжуулсан сул коксжих нүүрс	550,400	179,009,976,141
7	Баяжуулсан коксжих чанаргүй нүүрс	409,600	70,869,946,426
8	Чийг багатай хүрэн нүүрс	262,400	18,977,317,120
НИЙТ		12,537,600	3,044,424,109,658


График 2. Нийт нүүрсний арилжааны үнийн дүнд эзлэх хувь /бүтээгдэхүүний ангилаар/.



Нийт нүүрсний арилжааны үнийн дүнгийн 36.88 хувь буюу 1.12 их наяд төгрөгийг Дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрсний арилжаа, 24.46 хувь буюу 744.66 тэрбум төгрөгийг 1/3 коксжих нүүрсний арилжаа, 13.54 хувь буюу 412.3 тэрбум төгрөгийг Эрчим хүчний нүүрсний арилжаа, 12.8 хувь буюу 389.67 тэрбум төгрөгийг Баяжуулсан коксжих нүүрсний арилжаа, 5.88 хувь буюу 179.01 төгрөгийг Баяжуулсан сул коксжих нүүрсний арилжаа, 3.49 хувь буюу 106.17 тэрбум төгрөгийг Баяжуулсан дунд зэрэг үнстэй, хагас хатуу коксжих нүүрсний арилжаа, 2.33 хувь буюу 70.87 тэрбум төгрөгийг Баяжуулсан коксжих

чанаргүй нүүрсний арилжаа, 0.62 хувь буюу 18.98 тэрбум төгрөгийг Чийг багатай хүрэн нүүрсний арилжаа тус тус эзэлж байна.

График 3. Нийт нүүрсний арилжааны үнийн дүнд эзлэх хувь /худалдагч компаниар/.



Нүүрсний арилжааны нийт үнийн дүнгийн 49.62 хувь буюу 1.51 их наяд төгрөгийн арилжааг “Эрдэнэс Тавантолгой” ХК, 34.68 хувь буюу 1.06 их наяд төгрөгийн арилжааг “Тавантолгой” ХК, 9.74 хувь буюу 296.47 тэрбум төгрөгийн арилжааг “Энержи Ресурс” ХХК, 3.96 хувь буюу 120.46 тэрбум төгрөгийн арилжааг “Хангад Эксплорэйшн” ХХК, 1.39 хувь буюу 42.33 тэрбум төгрөгийн арилжааг “Мөнх Тэнүүн Оргил” ХХК, 0.62 хувь буюу 18.98 тэрбум төгрөгийн арилжааг “Андын Илч” ХХК тус тус эзэлж байна.

2025 оны III улирлын байдлаар нийт 213 удаагийн нүүрсний арилжаа амжилттай зохион байгуулагдсан. Үүнд:


- 1 дүгээр сард нийт 10 удаагийн нүүрсний арилжаагаар 256,000 тонн буюу 63.78 тэрбум төгрөгийн арилжаа,
- 2 дугаар сард нийт 4 удаагийн нүүрсний арилжаагаар 172,800 тонн буюу 59.17 тэрбум төгрөгийн арилжаа,
- 3 дугаар сард нийт 10 удаагийн нүүрсний арилжаагаар 249,600 тонн буюу 70.1 тэрбум төгрөгийн арилжаа,
- 4 дүгээр сард 21 удаагийн нүүрсний арилжаагаар 1,331,200 тонн буюу 348.29 тэрбум төгрөгийн арилжаа,
- 5 дугаар сард 4 удаагийн нүүрсний арилжаагаар 51,200 тонн буюу 16.32 тэрбум төгрөгийн арилжаа,
- 6 дугаар сард 6 удаагийн нүүрсний арилжаагаар 275,200 тонн буюу 52.53 тэрбум төгрөгийн арилжаа,
- 7 дугаар сард 24 удаагийн нүүрсний арилжаагаар 2,860,800 тонн буюу 748.16 тэрбум төгрөгийн арилжаа,
- 8 дугаар сард 63 удаагийн нүүрсний арилжаагаар 3,840,000 тонн буюу 924.75 тэрбум төгрөгийн арилжаа,

- 9 дүгээр сард 71 удаагийн нүүрсний арилжаагаар 3,500,800 тонн буюу 761.31 тэрбум төгрөгийн арилжаа тус тус амжилттай зохион байгуулагдсан.

2. Төмрийн хүдэр, баяжмалын арилжаа

График 4. Нийт арилжигдсан төмрийн хүдэр, баяжмал

Тайлант хугацаанд нийт 160 удаагийн арилжаагаар 4,151,700 тонн төмрийн хүдэр, баяжмалыг 902.25 тэрбум төгрөгөөр арилжсан. Үүнд: 3,326,700 тонн буюу 715.85 тэрбум төгрөгийн төмрийн баяжмал, 825,000 тонн буюу 186.4 тэрбум төгрөгийн төмрийн хүдэр тус тус арилжигдсан байна. Тодруулбал: Fe – 65%-ийн төмрийн баяжмал 287,100 тонн буюу 86.0 тэрбум төгрөг, Fe – 62%-ийн төмрийн баяжмал 26,400 тонн буюу 6.64 тэрбум төгрөг, Fe – 58%-ийн төмрийн баяжмал 3,013,200 тонн буюу 623.22 тэрбум төгрөг, Fe-52%-ийн төмрийн хүдэр 825,800 тонн буюу 186.4 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийсэн байна.



Хүснэгт 2. Нийт арилжигдсан төмрийн хүдэр, баяжмалын хэмжээ, үнийн дүн.

№	Бүтээгдэхүүний ангилал	Хэмжээ тн	Үнийн дүн ₮
1	Fe-58% Төмрийн баяжмал	3,013,200	623,215,288,143
2	Fe-52% Төмрийн хүдэр	825,000	186,401,018,876
3	Fe-65% Төмрийн баяжмал	287,100	86,000,957,163
4	Fe-62% Төмрийн баяжмал	26,400	6,637,590,960
НИЙТ		4,151,700	902,254,855,142

2025 оны III улирлын байдлаар нийт 160 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа амжилттай зохион байгуулагдсан. Үүнд:

- 1 дүгээр сард 30 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 1,010,100 тонн буюу 207.9 тэрбум төгрөгийн арилжаа,
- 2 дугаар сард 21 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 917,400 тонн буюу 185.33 тэрбум төгрөгийн арилжаа,
- 3 дугаар сард 14 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 145,200 тонн буюу 37.83 тэрбум төгрөгийн арилжаа,
- 4 дүгээр сард 19 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 660,000 тонн буюу 144.98 тэрбум төгрөгийн арилжаа,
- 5 дугаар сард 12 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 92,400 тонн буюу 21.85 тэрбум төгрөгийн арилжаа,
- 6 дугаар сард 13 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 135,300 тонн буюу 32.62 тэрбум төгрөгийн арилжаа тус тус амжилттай зохион байгуулагдсан.

- 7 дугаар сард 17 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 336,600 тонн буюу 78.09 тэрбум төгрөгийн арилжаа,
- 8 дугаар сард 20 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 729,300 тонн буюу 160.31 тэрбум төгрөгийн арилжаа,
- 9 дүгээр сард 14 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 125,400 тонн буюу 33.35 тэрбум төгрөгийн арилжаа тус тус амжилттай зохион байгуулагдсан.

График 5. Нийт төмрийн арилжааны үнийн дүнд эзлэх хувь /худалдагч компаниар/.



Дуудлага арилжааны үнийн өсөлтийн дундаж 5.89 хувь байна. Худалдагч компаниуд дуудлага арилжаагаар арилжигдсан төмрийн хүдэр, баяжмалын үнийн өсөлтөөс нийт 32.36 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна. Төмрийн хүдэр, баяжмалын арилжааны нийт үнийн дүнгийн 70.12 хувь буюу 632.63 тэрбум төгрөгийн арилжааг “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК, 29.88 хувь буюу 269.63 тэрбум төгрөгийн арилжааг “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ тус тус эзэлж байна.

3. Зэсийн баяжмалын арилжаа

Тайлант хугацаанд нийт 160 удаагийн зэсийн баяжмалын арилжаа амжилттай зохион байгуулагдаж, “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ нь 35.0 мянган тонн 22.35%-ийн зэсийн агуулгатай баяжмалыг 248.56 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Дуудлага худалдаагаар арилжсан зэсийн баяжмалын үнэ дунджаар 2.0 хувиар өсөж, худалдагч компани 3.49 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна.


4. Хайлуур жоншны хүдэр, баяжмалы нарилжаа

Тайлант хугацаанд нийт нийт 13 удаагийн хайлуур жоншны хүдэр, баяжмалын дуудлага арилжаа амжилттай зохион байгуулагдаж 41.47 тонн төмрийн хүдэр, баяжмалыг 43.28 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Хүснэгт 3. Нийт арилжигдсан хайлуур жоншны хүдэр, баяжмалын хэмжээ, үнийн дүн.

№	Бүтээгдэхүүний ангилал	Хэмжээ тн	Үнийн дүн ₮
1	CaF2-95% Хайлуур жоншны баяжмал	26,520	29,236,736,712
2	CaF2 97% хайлуур жоншны баяжмал	9,945	12,327,091,971
3	CaF2- <42% Хайлуур жоншны хүдэр	3,445	963,606,944
4	CaF2 <52% Хайлуур жоншны хүдэр	1,560	749,656,721
НИЙТ		41,470	43,277,092,348

График 6. Нийт жоншны арилжааны үнийн дүнд эзлэх хувь /худалдагч компаниар/.



Хайлуур жоншны хүдэр, баяжмалын арилжааны нийт үнийн дүнгийн 96.04 хувь буюу 41.56 тэрбум төгрөгийн арилжааг “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ, 3.96 хувь буюу 1.71 тэрбум төгрөгийн арилжааг “Очир Мандал Хайрхан” ХХК тус тус эзэлж байна. Дуудлага арилжааны үнийн өсөлтийн дундаж 14.19 хувь байна. Худалдагч компаниуд дуудлага арилжаагаар арилжигдсан хайлуур жоншны хүдэр, баяжмалын үнийн өсөлтөөс нийт 1.22 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖАА, БҮРТГЭЛИЙН ГАЗАР